

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ёс зүйн зөвлөл нь /цаашид “Зөвлөл” гэх/ Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан талаарх асуудлыг шалгаж, хариуцлага хүлээлгэх үндэстэй эсэх талаар дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий орон тооны бус нэгж мөн.

1.2. Зөвлөл нь Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3. Зөвлөл нь үйл ажиллагаандаа тэгш хандах, шударга ёсыг баримтлах, нууцыг хадгалах, хараат бус байх зарчмыг баримтална.

Хоёр. Ёс зүйн зөвлөл

2.1. Зөвлөл нь аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, алба бүрээс оролцсон 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 жил тутам шинэчилнэ.

2.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга батална.

2.4. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.

2.5. Зөвлөл нь ёс зүйн зөрчил, авилга, ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар хариуцлага хүлээж байгаагүй гишүүдээс бүрдэнэ.

2.6. Зөвлөлийн гишүүн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гишүүнээс чөлөөлж, нөхөн сонгоно.

2.7. Зөвлөл нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

2.7.1. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, санал, зөвлөмж өгөх;

2.7.2. Мэргэжлийн болон хувь хүний ур чадвар, хандлагад эерэг нөлөө үзүүлэх сургалт тогтмол зохион байгуулах;

2.7.3. Ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд дүн шинжилгээ хийж, учир шалтгааныг магадлан тогтоож шийдэх арга замыг тодорхойлох;

2.7.4. Хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагавар үүссэн нөхцөл байдлыг арилгах, зөрчил дахин давтагдахгүй байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

2.7.5. Төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг шалгаж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 4.2-т заасан хариуцлагыг хүлээлгэх тогтоол гаргана.

2.7.6. Ёс зүйн зөрчил, хариуцлагын талаар мэдээллийн сан бүрдүүлнэ.

2.7.7. Зөвлөлийн гишүүн нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлыг шалгах, нууцыг чанд хадгалах, хуралд оролцож санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хурлаас гарах шийдвэрт хариуцлагатай оролцох, ёс зүйн зөрчил гарсан эсэхэд саналаа хэлэх, зөвлөлийн даргын томилсноор зөвлөлийн хурлыг даргалах бүрэн эрхтэй.

2.7.8. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна зөвлөлийн хурлыг товлон зарлах, бэлтгэлийг хангуулах, хурлыг удирдах, гомдол, хүсэлтийг хүлээн авах, өөрийн эзгүйд зөвлөлийн хурлыг удирдах гишүүнийг томилж бүрэн эрхтэй.

2.8. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрт бүх гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулах, баримт бичгийг эмхэлж архивын нэгж болгох, зохих байгууллага, хувь хүнд ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг хүргүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

2.9. Ёс зүйн зөвлөлийн гишүүн дараах тохиолдолд гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй.

2.9.1. Гомдол, хүсэлтийг өөрөө гаргасан бол;

2.9.2. Тухайн албан хаагч гомдол, хүсэлт гаргасан этгээдтэй эсхүл тэдний гэр бүлийн гишүүдтэй төрөл, садан бол;

2.9.3. Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх үндэслэл байгаа бол;

2.10. Зөвлөлийн гишүүдийн 70 хувиас дээш ирцтэй хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

2.11. Хурлын шийдвэр гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

Гурав. Гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажиллагаа

3.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдлыг зөвлөлийн нарийн бичгийн дарга хүлээн авна

3.2. Гомдол хүлээн авагч нь нууцлалыг чанд хадгална.

Дөрөв. Зөвлөл гомдол, хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа

4.1. Ёс зүйн зөрчилтэй холбогдон гарсан гомдлыг 14 хоногийн дотор шалгаж, тогтоол гарган холбогдох байгууллага болон гомдол гаргагчид хариу мэдэгдэнэ.

4.2. Зайлшгүй тохиолдолд гомдлыг шалгах хугацааг 14 хоног сунгаж гомдол гаргагчид албан ёсоор мэдэгдэнэ.

4.3. Ёс зүйн зөвлөлийн тогтоол нь нотлох баримтад үндэслэгдсэн байна.

4.4. Зөвлөл нь төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол, мэдээллийг шалгаж ирүүлсэн танилцуулга, материалыг гишүүдийн ердийн олонхийн ирцтэй хуралдан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж байдлыг харгалзан, зөрчил гаргагчид дараах хариуцлагыг хүлээлгэх тогтоол гаргаж, зөрчил гаргасан албан хаагч болон томилох эрх бүхий этгээдэд танилцуулна.

4.4.1 уучлал гуйхыг үүрэг болгох /уучлал гуйх хэлбэрийг тодорхойлсон байна/

4.4.2 сануулах

4.5. Зөвлөл нь тогтоолын дагуу авсан арга хэмжээнд хяналт тавьж ажиллана.

4.5. Ёс зүйн зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай бичгээр хариу өгнө.

-----o0o-----